

**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

2017 ТАЙЛАН

Цахим хуудас: www.eri.mn
Хаяг: Эдийн Засгийн Судалгаа, Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (ЕРИ),
МУИС-ийн 5-р байр, 503 тоот, Нэгдсэн үндэстний гудамж,
Сүхбаатар дүүрэг, 6 хороо, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-11-353470
Э-Мэйл: contact@eri.mn

1. Алтны зах зээлийн судалгаа
2. Зэсийн зах зээлийн судалгаа
3. Төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа
4. Нүүрсний зах зээлийн судалгаа
5. Уул уурхайн салбарын хөгжлийн стратеги
6. Төсвийн орлогын менежмент
7. Уул уурхайн салбарын маркетинг ба борлуулалт
8. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт
9. Төсвийн хумих бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө
10. Шатахууны үнийн өсөлтийн эдийн засаг дахь нөлөө
11. Байгалийн баялагтай эдийн засаг дахь мөнгөний болон макро зохистой харьцааны бодлогын нөлөө: Монголын жишээ
12. Бэлчээрийн доройтол ба малын хөлийн татвар
13. Уул уурхайн салбарын орон нутгийн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөө: Монголын жишээ
14. Ипотекийн зээлийн бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө
15. Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, 2017 он

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Товч танилцуулга

МУИС-ийн дэргэдэх эдийн засгийн бодлого судлалын төв болох Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн 2010 онд байгуулагдсан. Чанарын өндөр түвшний, мэргэжлийн хөндлөнгийн хяналтаар шүүгдсэн, хараат бус, оновчтой асуудал дэвшүүлсэн эдийн засгийн бодлогын шинжилгээ, судалгааны ажлыг хийх, санхүүжүүлэх, эдгээр судалгааны гол үр дүнг нийтэд хүргэх, бодлогын судалгаа хийх хэрэгцээг тодорхойлж төрийн болоод бусад байгууллагад танилцуулах гол зорилготой.

Тус хүрээлэн МУИС-ийн эрдэмтэн, багш нарын судалгаа хийх чадавхад голлон суурилахаас гадна бусад судлаач, шинжээчдийг үйл ажиллагаандаа идэвхтэй оролцуулдаг.

Гол харилцагчид:

- ◀ Монголбанк, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам зэрэг төрийн байгууллага
- ◀ Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ, Жайка зэрэг олон улсын байгууллага

2017 онд хэрэгжүүлсэн судалгааны төслүүд

Алтны зах зээлийн судалгаа

Энэхүү судалгаа нь тус хүрээлэнгийн 2017 оны 3-р сард гүйцэтгэсэн “Алтны зах зээлийн судалгаа”-ны үргэлжлэл судалгаа юм. Энэхүү шинэчилсэн тайланд алтны дотоод, гадаад зах зээлийн өнөөгийн болон цаашдын чиг хандлагыг эрэлт, нийлүүлэлт, үнэ гэсэн гурван бүлгийн хүрээнд тодорхойлсон.

Дэлхийн зах зээл:

- ◀ Гоёл чимэглэл болон хөрөнгө оруулалтын зориулалттай эрэлт дэлхийн алтны нийт эрэлтийн дийлэнхийг бүрдүүлсэн хэвээр байна. 2017 оны эхний хагаст дэлхийн алтны эрэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан. Цаашид ч дэлхийн чиг хандлагатай уялдан гоёл чимэглэлийн алтны эрэлт буурах төлөвтэй байна. Мөн 2016 оны алтны үнийн хөөргөдлөөс хойш хөрөнгө оруулалтын зориулалттай алтны эрэлт ч үргэлжлэн буурах төлөвтэй байна. Технологийн зориулалттай болон төв банкны эрэлтийн хэмжээ өсөхөөр хүлээгдэж байгаа боловч нийт эрэлтэд эзлэх хувь харьцангуй бага тул нийт эрэлт буурах төлөвтэй байна.
- ◀ 2016 оны эхний хагастай харьцуулахад дэлхийн алтны нийлүүлэлт 2017 оны эхний хагаст буурчээ. Дэлхийн алтны нийлүүлэлт нь уурхайн үйлдвэрлэл, дахин боловсруулсан алт болон уурхайн үйлдвэрлэлд тулгуурласан үйлдвэрлэгчийн хеджинг (net producer hedging)-ээр тодорхойлогддог. 2017 оны эхний хагаст алтны уурхайн олборлолт өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөгдөөгүй боловч дахин боловсруулсан алтны хэмжээ буурч, үйлдвэрлэгчид алтны эрсдэлийн хамгаалалт хийхээсээ илүү хамгаалалтаа цуцлах нь (de-hedging) олширсон байна. Цаашид үйлдвэрлэл буурах хандлага үргэлжлэх бөгөөд дэлхийн хамгийн том алт олборлогч БНХАУ уул уурхайн салбартаа шинэчлэл хийж, алтны олборлолтоо системтэйгээр бууруулж байгаа тул алтны нийлүүлэлт буурах төлөвтэй байна.

- ◀ Алтны үнэ алтны нийт эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдоно. Алтны нийт нийлүүлэлт эрэлтээсээ илүү буурах хүлээлттэй байгаа учир 2018 онд дэлхийн алтны үнэ өндөр байх төлөвтэй байна. Дэлхийн эдийн засаг, ялангуяа АНУ-ын эдийн засгийн тогтворгүй байгаа учраас ойрын жилүүдэд алтны үнэ өсөх ба цаашид өссөн түвшиндээ тогтвортой байх хандлагатай байна.

Монголын зах зээл:

- ◀ Засгийн газрын Алт-2 хөтөлбөрийн дагуу Монголбанк алтны худалдан авалтаа өсгөх төлөвтэй байгаа тул дотоодын алтны эрэлт харьцангуй өндөр байхаар байна.
- ◀ Алтны үйлдвэрлэл Оюу Толгойн үйлдвэрлэлд голлон тулгуурладаг учраас Оюу Толгойн 2-р шат болох далд уурхайн өргөтгөл ашиглалтад орох 2020 он хүртэл Монголын алтны үйлдвэрлэл тогтвортой байх төлөвтэй байна. Түүнээс хойш алтны үйлдвэрлэл огцом өссөөр 2025 онд дээд цэгтээ хүрэх төлөвтэй. Алтны хэд хэдэн төсөл шинээр хэрэгжиж эхэлж байгаа тул үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдах хандлагатай байна.
- ◀ Монголын алтны үнэ дэлхийн зах зээлийн үнээс бүрэн хамааралтай тул дэлхийн үнийн чиг хандлагыг дагана.

Зэсийн зах зээлийн судалгаа

Энэхүү судалгаа нь ЭЗСЭШХ-ийн 2017 оны 3-р сард гүйцэтгэсэн “Зэсийн зах зээлийн судалгаа”-ны үргэлжлэл юм. Судалгаандаа бид 2017 онд дэлхийн болон дотоодын зах зээл дэх эрэлт, нийлүүлэлт, үнэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан.

Дэлхийн зах зээл:

- ◀ 2017 оны эхний хагаст дэлхийн зах зээл дээр зэсийн эрэлт буурсан бол хоёрдугаар хагаст БНХАУ-ын эдийн засаг хурдацтай өссөнөөр эрэлт буцаад сэргэх хандлагатай болсон. Салбарын шинжээчдийн таамаглалаар зэсийн дэлхийн эрэлт 2017 онд болон цаашид өсөх хандлага байна. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр, улмаар зэсийн хэрэглээ нь 2017-2018 онд өсөх төлөвтэй байна. Мөн АНУ, Европын эдийн засгийн өсөлт болон Энэтхэг зэрэг хөгжиж буй зах зээлүүдийн хурдацтай өсөлт дэлхийн зэсийн эрэлтийг цаашид үргэлжлүүлэн дэмжих төлөвтэй байна.
- ◀ Дэлхийн зэсийн баяжмалын нийлүүлэлт 2017 оны эхний хагаст эрс буурсан. Үүнд дэлхийн хамгийн томд тооцогдох уурхайнууд болох Эскондида, Кери Верде дэх ажил хаялт, Индонезийн засгийн газрын зэсийн баяжмалын экспортод тавьсан түр хориг зэрэг нөлөөлжээ. Харин боловсруулсан зэсийн нийлүүлэлт харьцангуй тогтвортой байна. Шинжээчдийн хүлээлтээр 2017 онд зэсийн уурхайн үйлдвэрлэл буурах төлөвтэй байна. 2019 он гэхэд зэсийн өсөж буй эрэлтийн хэмжээ нь харьцангуй тогтворжиж буй нийлүүлэлттэй тэнцэх хэмжээнд хүрч зэсийн зах зээл тэнцвэржих хандлагатай байна. Урт хугацаандаа зэсийн баяжмалын агууламж буурах, эрчим хүч, ус хомсдох зэргээс хамааран зэсийн нийлүүлэлт хязгаарлагдах төлөвтэй байна. Иймд 2020-иод оны эхээр нийлүүлэлтийн хомсдол үүснэ гэж шинжээчид үзэж байна.
- ◀ 2017 оны эхний 8 сард дэлхийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлтийн улмаас зэсийн үнэ өссөн. Олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудаас гаргасан үнийн таамаглалууд ихээр өөрчлөгдөж байна. Салбарын шинжээчид нийлүүлэлтийн хомсдол болон эрэлтийн өсөлтөөс үүдэн ирэх 5 жилийн хугацаанд төдийгүй цаашид зэсийн үнэ үргэлжлэн өснө гэж таамаглаж байна.

Монголын зах зээл:

- ◀ Монголын зэсийн зах зээлийн хувьд дотоодын эрэлт богино хугацаанд тогтвортой байх ба эдийн засгийн өсөлт, ялангуяа дэд бүтцийн хөгжлийн хурдцаас хамааран нэмэгдэнэ. Нийлүүлэлтийн хувьд ирэх хоёр жилийн хугацаанд дундаж агууламжийн бууралтаас хамааран зэсийн баяжмалын үйлдвэрлэл буурахаар хүлээгдэж байна. Хэдий тийм ч 2026 он гэхэд зэсийн үйлдвэрлэл өсөх төлөвтэй байна. Оюу толгойн газрын гүний уурхай болон Цагаан суварга уурхайн үйл ажиллагаа энэ өсөлтийн гол хөдөлгөгч болно.

Төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа

Энэхүү судалгаа нь тус хүрээлэнгийн 2017 оны 3-р сард хийсэн “Төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа”-ны үргэлжлэл юм. Энэ судалгаанд төмрийн хүдрийн гадаад ба дотоод зах зээлийн сүүлийн үеийн нөхцөл байдлыг тодорхойлж, цаашдын хандлагыг тодруулахыг зорилоо.

Дэлхийн зах зээл:

- ◀ 2016 онд дэлхийн гангийн үйлдвэрлэл 0.5%-ийн өссөн. Дэлхийн нийт түүхий гангийн үйлдвэрлэл 2017- 2019 онд алгуурхан өсөх төлөвтэй байна. 2017, 2018 онд дэлхийн нийт гангийн үйлдвэрлэл тус тус 4.4% болон 0.7% өснө гэж Австралийн үйлдвэрлэл, инноваци шинжлэх ухааны хүрээлэн таамаглаж байна. БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн өсөлт саарах хандлагатай байгаа ба энэ нь БНХАУ-ын засгийн газраас байгаль экологи болон технологийн хүчин зүйлээс шалтгаалж гангийн үйлдвэрлэлээ бууруулах бодлого баримталж байгаатай холбоотой.
- ◀ 2016 онд дэлхийн төмрийн хүдрийн үйлдвэрлэл өмнөх жилийнхээс 5% -аар өсөж 2106 сая тоннд хүрсэн. Энэхүү өсөлт Австралийн төмрийн хүдрийн үйлдвэрлэл 30 сая тонноор өссөнтэй холбоотой. Төмрийн хүдрийн нийлүүлэлт ойрын ирээдүйд өсөх төлөвтэй байна. Блүүмбэргийн таамаглаж байгаагаар 2018 онд төмрийн хүдрийн хамгийн том 4 компанийн үйлдвэрлэлийн хэмжээ 1.13 тэрбум тоннд хүрнэ. Энэ нь Австрали болон Бразилын төмрийн хүдэр олборлогч томоохон компаниуд үйл ажиллагаагаа өргөтгөн, зардлаа бууруулж байгаатай холбоотой.
- ◀ 2016 оны сүүлийн улирлаас төмрийн хүдрийн үнэ өссөн бөгөөд 2017 оны 2-р сарын байдлаар нэг тонн төмрийн хүдрийн үнэ 88.8 ам долларт хүрсэн. Үүний дараа төмрийн хүдрийн үнэ хэлбэлзэж, 2017 оны 9 сар гэхэд 71.5 ам долларт хүрчээ. 2018-2021 онд дэлхийн зах зээл дэх төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Учир нь 2020 он хүртэл төмрийн хүдрийн зах зээлд нийлүүлэлт илүүдэх төлөвтэй байна. ОУВС, Дэлхийн Банк, Блүүмбэргийн таамаглалаас үзэхэд, төмрийн хүдрийн үнэ буурч, 2021 онд дунджаар 53.1 ам доллар хүрэхээр байна.

Монголын зах зээл:

- ◀ 2016 онд Монгол улсын гангийн үйлдвэрлэл 5 мянган тонноор нэмэгдсэн бөгөөд цаашдаа гангийн үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна. Учир нь Засгийн газраас хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги баримталж байгаа ба үүний хүрээнд Дархан, Сэлэнгийн бүсэд, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжиж байна.
- ◀ Монгол Улсын төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн хүчин чадал 11.5 сая тонн хэдий ч 2016 онд нийт хүчин чадлын 65%-ийг ашигласан. Харин 2017-2020 онд Дархан Сэлэнгийн бүсэд Хар төмөрлөгийн үйлдвэр байгуулагдаж буйтай холбоотойгоор төмрийн хүдрийн олборлолт бүрэн хүчин чадалдаа хүрэх боломж нээгдэж байна.

Нүүрсний зах зээлийн судалгаа

Монголын нүүрсний экспортын 70-80 хувийг коксжих нүүрс бүрдүүлдэг учраас энэ судалгаанд коксжих нүүрсний зах зээлийг түлхүү авч үзлээ. Тус хүрээлэнгийн 2017 оны 3-р сард нийтэлсэн “Нүүрсний зах зээлийн судалгаа”-ны үргэлжлэл болох энэ тойм судалгаа эрэлт, нийлүүлэлт, үнэ гэсэн 3 бүлэгтэй. Бүлэг тус бүрд дэлхийн болон Монголын нүүрсний зах зээл, нөлөөлөгч гол хүчин зүйлсийг тодруулж авч үзсэн.

Дэлхийн зах зээл:

- ◀ Коксжих нүүрсний эрэлт гангийн үйлдвэрлэл болон үйлдвэрлэлийн техникээс хамаардаг. Байгаль орчны асуудлаас үүдэн улс орнууд коксжих нүүрс их хэмжээгээр ашигладаг ган хайлах зуухнаас татгалзаж, цахилгаан нумын зуухыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж байна. Гэхдээ гангийн үйлдвэрлэлийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг БНХАУ ган хайлах зуух голлон ашигладаг. 2017 оны 3-р сард БНХАУ нүүрс (коксжих болон эрчим хүч)-ний үйлдвэрлэлээ 150 сая тонноор бууруулах төлөвлөгөө олон нийтэд зарласан. Энэ хүрээнд байгаль орчинд хортой, стандартын шаардлага хангаагүй орон нутгийн жижиг уурхайнуудыг хаах шийдвэр гаргасан. Үүнээс үүдэн, Австрали, Монгол, ОХУ зэрэг коксжих нүүрс экспортлогчдын эрэлт огцом өссөн.
- ◀ Австралийн нүүрсний экспорт өнгөрсөн онд Дебби хар салхины нөлөөгөөр хэд хэдэн удаа тасалдаж, нүүрсний үнэ огцом өссөн. Энэ өсөлтийг ашиглахаар дэлхийн өнцөг булан бүрд нүүрсний уурхайнууд үйлдвэрлэлээ нэмсэн юм. Гэхдээ 2019 оноос нүүрсний үйлдвэрлэл хэвийн түвшиндээ эргэж очих төлөвтэй байна.
- ◀ Дэлхийн гангийн үйлдвэрлэл буурах хүлээлттэй байгаа учраас коксжих нүүрсний эрэлт буурна. Дунд болон урт хугацаанд эрэлтийн бууралтаас үүдэн зах зээлд үнэ буурна. Гэхдээ байгалийн гамшиг зэргээс шалтгаалан богино хугацаанд нийлүүлэлтийн сөрөг шокноос үүдсэн үнийн өсөлт ажиглагдаж болно.

Монголын зах зээл:

- ◀ 2017 оны коксжих нүүрсний нийлүүлэлтийн хомсдолоос үүдсэн үнийн огцом өсөлтийг Монголын нүүрсний компаниуд ашиглахын тулд үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн. Харамсалтай нь үйлдвэрлэлийн өсөлтөөс үүдэн “Гашуун сухайт” хилийн боомтоор нэвтрэх ачааны машины дараалал 100 километр үргэлжилж, Уул уурхай. хүнд үйлдвэрийн яам нүүрсний үйлдвэрлэл, экспортыг бууруулах шийдвэр гаргасан билээ.
- ◀ Түүхий гангийн үйлдвэрлэл буурна гэсэн хүлээлт коксжих нүүрсний үнийг бууруулахаар байна. Монголын коксжих нүүрсний үнэ дэлхийн зах зээлийн үнийг дагаж 2018 онд буурч, 2019 оноос тогтворжих төлөвтэй байна.

Уул уурхайн салбарын хөгжлийн стратеги

Монгол Улсын уул уурхайн салбарт баримталж буй хөгжлийн стратегийг хууль эрх зүйн үндсэн гурван баримт бичигт тусгажээ.

Монгол Улсын их хурлаас 2016 онд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” хэмээх баримт бичгийг баталсан. Үүнд нийгэм эдийн засгийн бодлогын зорилтууд болон хөгжлийн гол зорилгуудыг тусгасан.

Уул уурхайн салбарын хөгжлийн стратегийг тусгасан бодлогын өөр нэг баримт бичиг нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого 2014-2025” юм. Энэхүү бодлогын баримт бичигт тус салбарын хөгжлийн урт хугацааны, илүү нарийвчилсан үзэл баримтлалыг тусгасан.

“Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” нь уул уурхайн салбарын хөгжлийн стратегийг тодорхойлсон гурав дахь хууль тогтоомжийн баримт бичиг юм. Үүнд ойрын хугацааны зорилтууд болон үйл ажиллагааны хөтөлбөрүүд тусгажээ.

Нэн тэргүүнд бид бодит байдлыг мэдэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийн талаар бодит хүлээлттэй байх нь чухал юм. Цаашилбал, стратегийн баримт бичгүүдэд эдгээр хүлээлтийг тодорхой тусгах шаардлагатай. Салбарын үйл ажиллагааг хэт өөдрөг, эсвэл хэт гутрангиар харах нь эдийн засаг дахь уул уурхайн салбарын нөлөөг хэт өндөр, эсвэл хэт бага үнэлэхэд хүргэнэ.

Салбарын үндсэн стратеги, бодлогын баримт бичгүүд эрдэс бүтээгдэхүүний нөөц болон үнийн бодит таамаглалд үндэслэсэн байх шаардлагатай. Хэдий тийм ч, дээр дурдсан баримт бичгүүдээс үнийн таамаглал болон баялгийн нөөцийн талаарх тооцооллыг шууд олж харах боломжгүй байна. Ялангуяа эдгээр баримт бичигт байгалийн баялгийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхой тусгаагүй байна.

Хууль эрх зүйн гол баримт бичгүүдэд баялгийн нөөцийн үнэлгээ, тооцооллыг төдийлөн сайн тусгаагүй байна. Эрдэс баялгийн нөөцийн албан ёсны үнэлгээг “Уул уурхай болон геологийн жилийн тойм”-д анхдагч байдлаар тусгасан байдаг. Тиймээс мэдэгдэж буй уул уурхайн салбарын боломжит өргөжилт болон эрдэс баялгийн нөөцийн тооцоог бодлогын баримт бичигт тусгах нь баримт бичгүүдийг илүү сайжруулна.

Стратегийн болон түүний дагалдах баримт бичгүүдэд эрдэс бүтээгдэхүүний үнийн таамаглалуудыг тусгадаггүй нь урт хугацаанд уул уурхайн салбар эдийн засагт ямар нөлөөтэйг тодорхойлох боломжгүй болгож байна.

Мөн энэ судалгаанд эдийн засгийн уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг хэрхэн бууруулахыг авч үзсэн. 2016 оны байдлаар ДНБ-ий 20 орчим хувь, нийт аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн 71 хувийг уул уурхайн

салбар бүрдүүлжээ. Цаашилбал, салбарын ДНБ дэх шууд бус нөлөө нь 10 орчим хувь байна.

Хөгжлийн стратегийн баримт бичгүүд тус салбараас хэт хамааралтай байдлыг хүлээн зөвшөөрч, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих стратегийг тусгасан байна. Засгийн газар үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх замаар залгамж бодлогыг баримтлан эдийн засгийн төрөлжилтөд хүрэхийг зорьж байна. Тодруулбал, уул уурхайн бус салбарын экспортыг татварын бодлогоор дамжуулан дэмжихийг зорьж байгаа бол ус, дулаан, цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах, өрсөлдөөнийг дэмжих, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Хөнгөлөлттэй зээл”-ийг гаргах, шатахууны үнийг тогтворжуулах зэрэг арга хэмжээнүүдээр дамжуулан нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийн зардлыг бууруулахыг зорьж байна.

Хэдий дээр дурдсан гурван бодлогын баримт бичгүүд салбарын хөгжлийн зорилгуудыг тодорхойлдог ч тэргүүлэх чиглэл болон уул уурхайн бус салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийн зардал зэргийг тодорхойлоогүй. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд ямар зардлаар хэрхэн хэрэгжих талаар тодруулах шаардлагатай.

Хоёрдугаарт, байгалийн баялаг нь сэргээгдэхгүй нөөц учир ирээдүй хойч үеийнхэнд байгалийн нөөц баялгийн үр өгөөжийг үргэлжлүүлэн хүртээхийн тулд уул уурхайн салбарыг тогтвортой хадгалах, хөгжүүлэх улс орны урт хугацааны үзэл баримтлалыг хөгжлийн стратегид тусгасан байх шаардлагатай. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” болон “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” зэрэг үндэсний стратегийн баримт бичгүүд урт хугацааны үзэл баримтлалыг тодорхой тусгажээ.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д 2030 он гэхэд орлогын тэгш бус байдал болон ядуурлыг бууруулахуйц эдийн засгийн өндөр өсөлтөд хүрэх зорилтыг тусгажээ. Уул уурхайн салбарын зорилтууд геологи, геофизикийн чиглэлээр цогц судалгааг дэмжих, хайгуулын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, орд газрын нөөцийн хайгуулыг өргөн хүрээнд хийх, цахилгаан станц, усан хангамж болон тээврийн сүлжээ бүхий дэд бүтцийг хөгжүүлэх, уул уурхайн томоохон төслүүдийг эхлүүлэхэд чиглэсэн байна.

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын гол зорилтууд нийт иргэдэд хамгийн үр өгөөж бүхий бодлогуудыг онцгойлон дэмждэг. Тодруулбал, уул уурхайн салбарын бодлогын нэн тэргүүний зарчим бол салбарын бодлогыг урт хугацаанд хадгалж үлдэх юм.

Хойч үед хүрэх салбарын урт хугацааны нөлөө нь зөвхөн өнөөгийн мэдэгдэж буй нөөц болон төслүүдийг хөгжүүлэх, ашиг хүртэхээс хамаарах бус, тухайн улсын хайгуул болон олборлолтын сонгон шалгаруулалтын зохицуулалт, төсөлд оролцож буй уул уурхайн компаниудтай холбоотой сангийн бодлого, уул уурхайн салбараас орж ирж буй орлогын менежмент, хувийн секторын дэмжлэг зэргээс хамаарна.

Сонгон шалгаруулалтын удирдамжийг Монгол Улсын “Ашигт малтмалын тухай хууль”-аар зохицуулагддаг. Тус хууль нь сонгон шалгаруулалтын үйл явцыг зохицуулахад чиглэсэн ч сонгон шалгаруулалтын явцад үүсэх асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдээгүй. Үнэн хэрэгтээ “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д сонгон шалгаруулалтын үйл явцыг тусгасан ямар ч дагалдах баримт бичиг байхгүй байна.

Уул уурхайн салбараас урт хугацаанд үр өгөөж хүртэхийн тулд тухайн улс салбараас хэрхэн ашиг хүртэх, ирээдүйд ямар өгөөж өгөхийг үнэлэх шаардлагатай. Монгол Улс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татвар, экспортын тариф ногдуулах, төрийн өмчийн ногдол ашиг хүртэх зэргээр уул уурхайн салбараас ашиг хүртдэг. Энэ нь олон нийтийн дунд хамгийн их яригддаг буюу маргаан дагуулсан сэдвүүдийн нэг юм.

“Ашигт малтмалын тухай хууль”-д үндэсний аюулгүй байдал болон нийгэм эдийн засагт ихээхэн нөлөөтэй, эсвэл ДНБ-д 5 хувиас дээш хувь нэмэр оруулж чадахуйц орд газрыг стратегийн ач холбогдолтой гэж үздэг. Хэдий тийм ч “стратегийн ач холбогдол бүхий орд”-д ямар шалгуур тавигдах нь бүрэн тодорхой бус бөгөөд тодруулга хийх шаардлагатай.

Оюу Толгой төслийн туршлагаас харахад бодлого боловсруулагчид урт хугацаанд манай улс төрийн өмчлөлөөрөө дамжуулан уул уурхайн ашиг хүртэх болно гэж мэдэгдсэн. Гэсэн хэдий ч, төрийн өмчит компаниудын үр ашиг, ашигт ажиллагаа нь хувийн өмчит компаниудынхаас хоцрогдолтой бөгөөд төрийн өмчит компаниудын удирдлагын баг тогтмол солигддог нь улс төрчдөд эдгээр компанид нөлөөлөх хүчтэй сэдэл байдгийг харуулж байна.

Урт хугацааны үр өгөөж нь мөн тухайн улс эрдэс бүтээгдэхүүнээс орсон орлогоо хэрхэн удирдахаас хамаарна. Монгол Улс уул уурхайн салбарын орлогыг зохицуулах тал дээр томоохон алхам хийсэн. Тодруулбал, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийг 2012 онд баталж, 2013 оноос бүрэн хэрэгжүүлж байна. Мөн 2016 онд “Ирээдүйн өв сангийн тухай хууль”-ийг 2016 онд баталсан.

Орлогын менежментийн дүрэм журмууд маш сайн хэлбэрт бичигдсэн хэдий ч Засгийн газар хэрэгжүүлэх түвшинд маш олон хүндрэлтэй тулгарч буйг дурдах нь зүйтэй. Тухайлбал, төсвийн алдагдал болон өрийн түвшин гэх мэт гол параметрууд өссөн үед үүнд хуулийг тохируулахын тулд жил бүр хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна. Параметруудын утгыг жил бүр өөрчилж буй нь Засгийн газрын төсвийн сахилга бат муу байгааг харуулж байна.


Ерөнхийдөө энэхүү үнэлгээний үр дүнд бид Засгийн газар стратегийн зорилгуудад хүрэх, бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд илүү өргөн хүрээтэй, нарийвчилсан төлөвлөгөө дутагдалтай байгааг онцолж байна.

Төсвийн орлогын менежмент

Сүүлийн арван жилд Монголын эдийн засаг унаж, өсөж, хүчтэй савлаж иржээ. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамикаас дүгнэхэд эдгээр өсөлт, уналт эрдэст бүтээгдэхүүний үнэ болон хөрөнгө оруулалтын хэлбэлзлээс хүчтэй хамаарч байжээ. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын өсөлт, бууралт манай улсын эдийн засгийн өсөлт, бууралтыг үндсэндээ тодорхойлж байна. Тухайлбал, эрдэст бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр хурдацтай унаж эхэлсэн 2012 оноос эдийн засгийн өсөлт саарч эхэлснийг түүхэн тоон мэдээллээс тодорхой харж болно. Энэ хугацаанд, төсвийн орлого тасалдаж байхад төсвийн зарлага нэмэгдсэнээр улсын гадаад өр огцом өсжээ. Улсын төсвийн орлого тасрах суурь шалтгаан нь төсөв батлахдаа түүхий эдийн үнийн хэт өөдрөг таамаглалд суурилж байсантай холбоотой.

Эдийн засгийн хэлбэлзлийг бууруулахад сангийн болон мөнгөний бодлогыг ашигладаг ба эдгээр бодлого мөчлөг сөрсөн шинжтэй байх ёстойг олон улсын туршлага харуулдаг. Гэтэл Монгол Улсын сангийн болон мөнгөний бодлого эдийн засгийн хэлбэлзлийг бууруулах биш, харин ч нэмэгдүүлж байсныг доорх зургаас харж болно.

Зураг 1. ДНБ, төсвийн зарлага ба мөнгөний нийлүүлэлт (M2)-ийн өөрчлөлт, хувиар



Эх үүсвэр: Монголбанк ба УЦХ

Засгийн газар, Улсын Их Хурал 2010 онд “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль” (ТТБТХ)-ийг баталсан. Уг хуулийн зорилго нь сангийн бодлогыг мөчлөг сөрсөн шинжтэй болгох, уул уурхайн салбар, ялангуяа эрдэст бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс үүдсэн эдийн засаг дахь сөрөг нөлөөг бууруулахад чиглэж байв. Гэхдээ УИХ уг хуульд нэмэлт оруулж, эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор хуулиас төсвийн зардлын өсөлт, ЗГ-ийн гадаад өрийн ДНБ-д

эзлэх хувь, төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь зэргийг тогтоосон заалтуудын хэрэгжих хугацааг 2017, 2021, 2023 он болгож түр хойшлуулсан юм. Ойрын ирээдүйд улсын гадаад өрийн эргэн төлөлттэй холбоотойгоор улсын төсөвт томоохон дарамт үүсэх учраас эдгээр гол заалтыг хэрэгжүүлж эхлэх шаардлага чухлаар тавигдаж байна.

Энэхүү судалгаанд ТБТХ-ийг хэрэгжүүлснээр эдийн засагт түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэх эрсдэлийг бууруулах боломжийг судаллаа. Судалгааны баг ТБТХ-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөг үнэлэхдээ Сангийн яам, Монголбанк, олон улсын байгууллагуудын түүхэн тоон мэдээллийг цуглуулж, Ерөнхий тэнцвэрийн загвар (CGE)-т тохируулан хувиргаж ашигласан.

Судалгааны гол үр дүн:

- ◀ ТБТХ хэрэгжих үед уул уурхайн бус салбарын өсөлт өндөр буюу уул уурхайн салбарын сөрөг дам нөлөө буурч байна;
- ◀ ТБТХ хэрэгжсэнээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн дундаж утгад төдийлөн нөлөөлөхгүй боловч өөрчлөлтийн стандарт хазайлтыг эрс бууруулна.

Өөрөөр хэлбэл, ТБТХ-ийг хэрэгжүүлснээр дэлхийн зах зээл дээр эрдэст бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэлтэй үед ч Монголын эдийн засаг харьцангуй тогтвортой байх боломж бүрдэж байна. Энэ үр дүнд үндэслэн дараах бодлогын зөвлөмжийг дэвшүүлсэн.

- ◀ ТБТХ-ийг хэрэгжүүлснээр мөчлөг сөрсөн сангийн бодлого баримтлах суурь нөхцөл бүрдэж, уул уурхайн салбар, ялангуяа эрдэс бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс үүдэлтэй эдийн засаг дахь хэлбэлзлийг бууруулна. Тиймээс тус хуулийн хойшлуулсан гол заалтуудыг аль болох яаралтай хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй.
- ◀ Уул уурхайн салбараас хамааралтай эдийн засагт хүндрэл үүсэж, хямралын шинж тэмдгүүд ажиглагдах үед ТБТХ-ийн хүрээнд үүсгэсэн төсвийн тогтворжуулалтын сангийн гүйцэтгэх үүрэг үлэмж их юм. Тиймээс Засгийн газар төсвийн тогтворжуулалтын санд төвлөрөх хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.
- ◀ Засгийн газар төсвөөс гадуурх зардлаа нэмэгдүүлэхгүй, төсвийн сахилга батыг хатуу сахих шаардлагатай.

Уул уурхайн салбарын маркетинг ба борлуулалт

Монголын уул уурхайн салбар сүүлийн арав гаруй жил эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч, гадаад валютын нөөцийн эх үүсвэр болж ирсэн. Гэхдээ түүхийн эдийн экспортын үйл ажиллагаанд ноцтой бэрхшээлүүд байсаар байна. Бусад барааны экспортой адил, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь худалдан авагчаа олох, гэрээ байгуулах, санхүүжилт шийдэх, тээвэрлэх, гэрээг хаах гэсэн үе шатуудыг дамжина. Энэхүү судалгаа уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үе шат бүрд тулгарах бэрхшээлүүдийг тодруулж, тэдгээрийг шийдэх арга замыг тодорхойлох зорилготой.

Уул уурхайн бүтээгдэхүүн бүрийн зах зээл өөрийн онцлогтой, үнэ тогтоолт, борлуулалтын үйл явц нь ялгаатай. Зах зээлийн энэ онцлог асуудлуудыг тодруулахын тулд уул уурхайн компаниуд, салбарын шинжээчид, мэргэжлийн холбоодтой ярилцлага хийж мэдээлэл цуглуулав. Ярилцлага судалгаанд түүхий эд экспортлогч 8 компани, салбарын төлөөлөл 9 байгууллага, хувь хүн хамрагдсан. Мөн салбарын мэдээлэл, судалгаа, олон улсын туршлагыг тодруулах баримт бичгийн шинжилгээ нэмж хийсэн. Тус салбарын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар, нүүрс, төмрийн хүдрийн экспортлогчид илүү хүнд бэрхшээлтэй тулгарч байгаа тул уг судалгаанд эдгээр бүтээгдэхүүний экспортыг голлон авч үзлээ.

Монголын коксжих нүүрсний экспортын үйл ажиллагаа Өмнөговь аймаг дахь Таван толгой, Нарийн сухайтын нүүрсний ордуудад төвлөрдөг бөгөөд гол зах зээл нь Хятадын хойд мужууд юм. Мөн Ховд аймаг дахь Хөшөөтийн уурхай Хятадын баруун хойд хэсэгт нүүрс экспортолдог. Ихэнх компани нүүрсээ Винсвэй холдинг гэх мэт Хятадын жижиг, дунд хэмжээний зуучлагчдаар дамжуулан борлуулдаг. Учир нь, зуучлагчид тээвэр, логистикийн асуудлаа хариуцаж, төлбөрийн уян хатан нөхцөл санал болгодог. Ялангуяа түүхий эдийн үнэ өндөр байх үед худалдан авагч олох, гэрээ байгуулахад хялбар байдаг. Зах зээл эрсдэл ихтэй, захиалгын хэмжээ бага байдаг учраас ихэнх борлуулалт хэмжээ багатай, урьдчилгаа төлбөр бүхий нэг удаагийн гэрээгээр хийгддэг. Иймээс гэрээ зөрчсөнтэй холбоотой маргаан бараг гардаггүй. Зардлыг нь ухрааж тооцвол томоохон компаниуд нүүрсээ дэлхийн зах зээлийн үнэтэй ойролцоо зардаг бол жижиг компаниуд хямд үнээр зарах хандлагатай байна. Саяхнаас Эрдэнэс таван толгой компани нүүрсээ дуудлага худалдаагаар борлуулж эхэлжээ.

Нүүрсийг голчлон автозамаар улсын хил хүртэл тээвэрлэж байна. Таван толгой ордоос улсын хил хүрэх зай 270 км, төмөр зам барих ажил олон жил саатаж буйн улмаас нүүрсийг өндөр зардалтай тээвэрлэж байна. Мөн нүүрс зөөх автозамын ачаалал их, БНХАУ талын хил, гаалийн нэвтрүүлэх чадвар хязгаарлагдмал байгаа зэргээс шалтгаалан нүүрс тээвэрлэлт маш их хугацаа алдаж, нэмэлт зардал гардаг. Үүнээс гадна, хилийн боомт олон улсын биш, харин орон нутгийн зэрэглэлтэй учраас БНХАУ-ын орон нутгийн захиргаа хил

нэвтрэх болон тээвэрлэлтийн хураамжийг гэнэт нэмэх эрсдэл гардаг. Харин нүүрсний бусад ордод олборлолт хийж буй компаниуд улсын хилд ойр, автозамын ачаалал бага, хил нэвтрэхэд хялбар зэрэг давуу талтай байна.

Төмрийн хүдрийн экспортлогчдод мөн тээвэр логистикийн асуудал гол бэрхшээл болдог. Хамгийн том экспортлогч Болд төмөр ерөө гол компани бүтээгдэхүүнээ төмөр замаар (уурхайгаас төв зам хүртэл 70 км төмөр зам өөрсдөө барьсан) тээвэрлэж Хятадын хойд хэсгийн гангийн үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Уурхайгаас БНХАУ-ын хил хүртэл 1100 км зайтай боловч төмөр замын цор ганц Улаанбаатар төмөр зам дотоодын зорчигч ба ачаа тээврийн алдагдлаа нөхөхийн тулд төмрийн хүдрийн холын тээврийн тариф хөнгөлдөггүй, хилээр нэвтрэх хураамж өндөр тогтоодог. Улсын хилээс цааш Бугатын гангийн үйлдвэр хүртэл тойруу замаар дахин 908 км тээвэрлэдэг. Уг замаас 318 км-ээр дөт түүхий эд тээвэрлэх төмөр зам барих төслийн судалгаа хийгдсэн боловч албан ёсоор хэлэлцэгдэж, батлагдаагүй байна.

Бүтээгдэхүүний онцлог шинж, зах зээлийнхээ хөгжлөөс хамаараад нүүрс ба төмрийн хүдрийн экспортлогчид татвар ногдуулалт гэх мэт нэмэлт асуудалтай тулгардаг. Нэг талаас, түүхий эдийн бирж болон худалдааны платформ байхгүй, татварын байгууллагад үзүүлж буй компаниудын борлуулалтын гэрээ ил тод биш, найдваргүй. Нөгөө талаас, Ашигт малтмалын тухай хуульд зааснаар, нүүрс ба төмрийн хүдрийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Хятадын далайн боомтын үнэ ба түүхий эдийн боловсруулалтын түвшнээс хамааруулж тогтоодог. Компаниудын мэдээлж буйгаар татварын түвшнийг ингэж түвэгтэй тооцох нь татвар төлөлт, тайлагналтад бэрхшээл учруулдаг аж.

Харин зэс, цайрыг дэлхийн түүхий эдийн биржүүд дээр арилжаалдаг учраас Оюу толгой, Эрдэнэтийн зэсийн баяжмал, Цайрт минералын цайрын баяжмал стандарт гэрээгээр (гэхдээ гэрээ нь ил тод биш) борлуулагддаг. Эрдэнэт, Цайрт минерал компаниуд баяжмалаа төмөр замаар тээвэрлэдэг бол Оюу толгой авто замаар тээвэрлэдэг. Баяжмал нь овор хэмжээ харьцангуй багатай. Иймээс эдгээр бүтээгдэхүүний борлуулалтын асуудал нүүрс, төмрийн хүдрийг бодвол бага. Цайрын баяжмал экспортлоход тулгарах гол бэрхшээл нь, бүтээгдэхүүний дээжийг Улаанбаатар хот руу илгээж Геологийн төв лабораторид шинжлүүлж хариу авах хооронд вагонтой ачааг Сайншанд өртөөнд хүлээлгэх хугацаа, зардал юм.

Уул уурхайн компаниудын ихэнх нь судалгааны чадавх, бизнесийнхээ загвартай холбоотойгоор маркетингийн нарийвчилсан судалгаа хийдэггүй ажээ. Энэ нь тэдний зах зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Өөр нэг асуудал нь манай улсад гадаад худалдааны төлбөр тооцоо, даатгал гэх мэт экспортын санхүүжилтийн үйлчилгээ сул хөгжсөн явдал юм. Үүний улмаас, жишээ нь, нүүрс экспортлогчид уурхайн амнаас нүүрсээ 30 хувийн урьдчилгаа аван шууд ачихыг илүүд үзэж байна. Энэ нь томоохон зуучлагчид, худалдан авагчдын сонирхлыг бууруулж, экспортлогчдын өрсөлдөх чадварыг бууруулж байж болзошгүй юм.

Судалгааны үр дүнд үндэслээд дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- ◀ Түүхий эдийн бирж, арилжааны платформ байгуулах шаардлагатай. Энэ талаарх урьдчилсан судалгаа, бэлтгэл ажлуудыг УУХҮЯ урьд нь хийж байсан.
- ◀ Бодлогын түвшинд зуучлагчдын үйл ажиллагааг дэмжих, үүрэг ач холбогдлыг зөвөөр ойлгох шаардлагатай. Худалдааны тухай хууль батлан зуучлагчдын үйл ажиллагааг зохицуулах боломжтой.
- ◀ Уул уурхайн компаниуд, ялангуяа төрийн өмчийн компаниуд бүх гэрээг, тэр дундаа борлуулалтын гэрээг ил тод болгох шаардлагатай.
- ◀ Экспортын санхүүжилтийн үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай. Экспорт импортын банк байгуулах шийдэл байж болно. Үүнийг бодлогын судалгаа хийж нарийвчлан тодруулах шаардлагатай.
- ◀ Уул уурхайн компаниуд, төрийн агентлаг, салбарын мэргэжилтнүүдийг уул уурхайн гэрээ, борлуулалт, татвар, засаглалын чиглэлээр тогтмол чадавхжуулах хэрэгтэй.
- ◀ Уул уурхайн салбарын ассоциаци, мэргэжлийн холбоодын оролцоог бодлого боловсруулах үйл ажиллагаанд нэмэгдүүлэх шаардлагатай. Эдгээр холбоод, мэргэжлийн байгууллагууд салбарынхаа талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой.


Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

Хөгжиж буй улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь эдийн засгийн өсөлтийг дэмжих нэг гол хүчин зүйл байдаг. Энэ судалгаанд ГШХО-ын Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө, ГШХО-ын урсалд нөлөөлдөг гол хүчин зүйлс болон ойрын хугацаанд ГШХО-ыг нэмэгдүүлэхэд анхаарах зүйлсийн талаар судаллаа.

ГШХО-ын Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэхдээ судалгааны баг 2010 болон 2015 оны орц-гарцын хүснэгт буюу салбар хоорондын тэнцлийг ашиглалаа. Салбар хоорондын тэнцэл нь эдийн засгийн бүтэц, салбар хоорондын нөөцийн урсгалыг харуулдаг учраас энэ төрлийн судалгаанд өргөн ашиглагддаг. Судалгаанд сонгосон хоёр оныг харьцуулбал, 2010 онд ГШХО өсөж, 2015 онд буурчээ. Уул уурхайн салбарт орсон нэмэлт хөрөнгө оруулалтын нийт эдийн засагт үзүүлэх нөлөөгөөр дамжуулж ГШХО-ын нөлөөг судлав. ГШХО-ын эдийн засагт үзүүлэх нөлөө ба үржүүлэгчийн утга нь эерэг бөгөөд уул уурхайн салбарт оруулсан хөрөнгийн дотоод зах зээл ба импортод зарцуулагдах харьцаанаас ихээхэн хамаарч байгааг судалгаагаар тогтоогдсон. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын дотоод зах зээлд шингэх хувь их байх тусам түүний эдийн засагт үзүүлэх нөлөө болон үржүүлэгч их байна.

Мөн судалгаагаар ГШХО-ын урсгал ямар хүчин зүйлсээс хамаарч буйг тодруулсан. Ингэхдээ ГШХО-д нөлөөлж буй хүчин зүйлсийг экзоген, эндоген хоёр бүлэгт хувааж үзсэн. Экзоген буюу гадаад хүчин зүйлд эрдэст бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийг оруулсан. Учир нь манай улс энэ үнэд нөлөөлөх чадваргүй, үнэ хүлээн авагч улс юм.

Зураг 2. Түүхий эдийн үнийн индекс ба ГШХО, 2009-2016



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ, Дэлхийн банк, судалгааны багийн тооцоолол

Харин олон улсад хийгддэг судалгааны жишгээр, хөрөнгө оруулалтыг эндоген хүчин зүйл гэж авч үзсэн. Фрэйзер институт уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн удирдлагуудаас жил бүр асуулга судалгаа авч, тэдний хөрөнгө оруулалтын шийдвэрт ямар хүчин зүйлс нөлөөлж буйг тодруулдаг. Асуулгын үр дүнд үндэслэн улс орнуудын “Хөрөнгө оруулалт татах индекс”-ийг танилцуулдаг. Уг индекс нь бодлогын орчин болон байгалийн баялгийн индексийн дунджаар тодорхойлогддог.

Хүснэгт 1. Монгол, Чилийн индекс, 2015-2017

	Хөрөнгө оруулалт татах индексийн эрэмбэ	Бодлогын орчны индексийн эрэмбэ	Байгалийн баялагийн индексийн эрэмбэ
Монгол			
2015	85/109	94/109	59/109
2016	81/104	101/104	50/104
2017	53/91	70/91	36/91
Чили			
2015	11/109	26/109	11/109
2016	39/104	35/104	49/104
2017	8/91	25/91	7/91

Эх сурвалж: Fraser Institute

Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн удирдлагууд хэрхэн дүгнэж байгааг дээрх хүснэгтээс тодорхой харж болно. Уул уурхайн салбарт түшиглэж, амжилттай хөгжиж буй Чилитэй харьцуулахад манай улсын бизнесийн орчны хөрөнгө оруулалт татах чадвар сул байна. Тиймээс Чили гэх мэт улсын туршлагыг судлах шаардлагатай юм.

Манай улсын хувьд эрдэст бүтээгдэхүүний үнэ гэх мэт ГШХО-ын урсгалыг тодорхойлогч экзоген хүчин зүйлсэд нөлөөлөх боломжгүй. Тиймээс цаашид ГШХО-ыг нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулж, ГШХО-ын урсгалыг удирдах шаардлагатай байна. Байгалийн баялаггүй боловч их хэмжээний ГШХО-ыг ихээр татдаг Сингапур, Швейцар, Хонконг гэх мэт улсууд байдаг. Эдгээр улсад улс төр тогтвортой, санхүүгийн зах зээлийн өндөр хөгжилтэй, зах зээлд нэвтрэхэд хялбар, дэд бүтэц болон хүмүүн капитал сайтай зэрэг нь хөрөнгө оруулалт татах суурь нөхцөл болдог.

Монгол Улс урт хугацааны хөгжлийн хандлагыг тодорхойлох “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрүүдэд олон тооны мега төсөл эхлүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 2. 2017 оны бизнесийн орчны үзүүлэлтүүд ба эрэмбэ

Индекс	Эрэмбэ			
	Сингапур	Швейцар	Хонконг	Монгол
Авлигын индекс	6/180	3/180	13/180	103/180
ЭЗ-ийн эрх чөлөөний индекс	2/180	4/180	1/180	125/180
Бизнес эрхлэлтийн индекс	2/190	33/190	5/190	62/190
Дэлхийн инновацийн индекс	7/127	1/127	16/127	52/127

Эх сурвалж: *Transparency International, Heritage Foundation, Дэлхийн банк, Корнель INSEAD WIPO*

Гэхдээ эдгээр төслүүдийг ГШХО-оор санхүүжүүлэхээр тусгасан нь санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойгүй болгож байгаа юм. Монгол Улс дахь ГШХО-ын урсгалыг эрдэст бүтээгдэхүүний үнэ түлхүү тодорхойлж буй өнөө үед эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц мега төслүүдээ ГШХО-оор санхүүжүүлэх тохиолдолд таамаглаж буй ГШХО-ын нийлүүлэлт хүрэлцэхгүй байх эрсдэлтэй.

Судалгааны үр дүнгээс дараах зөвлөмжүүдийг дэвшүүлж байна.


Нэгдүгээрт, ГШХО-ыг татахаас гадна, дотоод зах зээлдээ шингээхэд анхаарах хэрэгтэй. Ингэснээр, эдийн засагт үзүүлэх нөлөө болон ГШХО-ын үржүүлэгч өндөр байх болно. Хоёрдугаарт, ГШХО-ын урсгалыг тодорхойлж буй эрдэст бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөд манай улс нөлөөлөх боломжгүй учраас хөрөнгө оруулалтын орчноо сайжруулахад анхаарах шаардлагатай.

Төсвийн хумих бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө

Энэ судалгааг Эдийн засгийн бодлогын хамтын ажиллагааны байгууллагын (PEP) санхүүгийн болон арга зүйн дэмжлэгтэйгээр, “Институтийг дэмжих төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Монголын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай буюу дунджаар нийт экспортын 94%, төсвийн орлогын 20% орчмыг уул уурхайгаас бүрдүүлдэг. 2010-2013 онд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтийн улмаас Монголын эдийн засаг хурдтай өссөн. Харин 2013 оноос хойш уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтаас шалтгаалж эдийн засгийн өсөлт удааширсан билээ.

Зураг 3. Төсвийн алдагдал (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Country report No. 17/140, Article 4, IMF

Засгийн газар эдийн засгийн хямралаас сэргийлэхийн тулд ОУВС-тай Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн гэрээ байгуулсан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улс 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт авах бөгөөд өр болон эдийн засгийн өсөлтийг зорилтот хэмжээнд хүргэхийн тулд засгийн газар зардлаа (засгийн газрын бараа бүтээгдэхүүний худалдан авалт, капиталын зардал болон өрхүүдэд шилжүүлж буй шилжүүлэг зэрэг) бууруулж, татварын хэмжээг өсгөх шаардлага тулгарсан.

ОУВС-ийн тооцоолсноор Монгол Улс төсвийн сахилга батыг сахиж чадвал 2014 онд ДНБ-ийн 11.3% -ийг эзэлж байсан нийт төсвийн алдагдлыг 2022 он гэхэд 1.5%-д хүргэж бууруулах боломжтой.

Энэхүү судалгаагаар экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн зах зээлийн үнийн ялгаатай нөхцөлд засгийн газрын зардлын бууралт эдийн засагт ямар нөлөө үзүүлэхийг үнэлсэн.

Судалгааны баг 2014 оны Монголын нийгмийн тооцооллын хүснэгтийг байгуулж, судалгааны тоон мэдээлэл болгон ашигласан. PEP стандартын статик тооцоолох ерөнхий тэнцвэрийн загвар (CGE) -ыг ашиглан 3 хувилбарын үнэлгээ хийсэн.

Суурь хувилбар	Сөрөг хувилбар	Эерэг хувилбар
ОУВС-ийн төсөөллийн дагуу төсвийн зарлагаа 2014-2022 онд 72.4% бууруулна, нүүрс болон зэсийн дэлхийн зах зээлийн үнэ 2014 оны түвшинд байна	Төсвийн зарлагыг 72.4% бууруулна, харин зэсийн үнэ 2014 онтой харьцуулахад 29% буурна (2010-2016 оны хамгийн бага түвшинд хүрнэ), нүүрсний үнэ 13.4% буурна (2010-2016 оны хамгийн бага түвшинд хүрнэ).	Төсвийн зарлагыг 72.4% бууруулна, харин зэс болон нүүрсний үнэ 2014 онтой харьцуулахад 29% өснө (2011 оны үнийн түвшинд хүрнэ), нүүрсний үнэ 76% өснө (2017 оны үнийн түвшинд хүрнэ).

Эхний 2 хувилбарын хувьд засгийн газрын хөрөнгийн зардал 18.6%-аар буурна гэж үзсэн. Харин эерэг хувилбарын хувьд, засгийн газар төсвийн алдагдлыг төлөвлөсөн хэмжээндээ хүргэхэд харьцангуй хялбар байх тул хөрөнгийн зардлыг өөрчлөхгүй гэсэн таамаглал тавьсан.

Судалгааны гол үр дүн

Төсвийн зарлагын бууралтын эдийн засаг дахь нөлөө Монголын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн хэлбэлзлээс хамааран ялгаатай байна. Эерэг болон сөрөг хувилбаруудын хувьд засгийн газрын татварын орлого өөрчлөгдөж байгаа тул төсвийн алдагдлыг зорилтот түвшинд барихын тулд засгийн газрын зардлуудын бууралт суурь хувилбараас ялгаатай байна.

◀ Суурь хувилбар

Төсвийн зарлагын бууралт макро эдийн засагт ихээхэн сөрөг нөлөөтэй байна. Төсвийн алдагдлыг зорилтот хэмжээнд хүргэхийн тулд Засгийн газар бараа үйлчилгээнд зарцуулах зардлаа 25.8% (8 жилийн хугацаанд, жилтүгэм 3.7%) бууруулах, өрхүүдэд шилжүүлэх шилжүүлгийг 24% (жилд 3.4%) бууруулах, хөрөнгийн зардлыг 18.6% (жилд 2.5%) бууруулах шаардлагатай болно.

Засгийн газар гол хэрэглэгч нь болдог учраас Засгийн газрын зарлагын бууралт боловсрол, эрүүл мэнд, урлаг, усан хангамж зэрэг салбаруудын эрэлтийг бууруулж, улмаар үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг нь бууруулна. Гэхдээ үүнтэй зэрэгцэн нийт хөрөнгө оруулалт нэмэгдэж хөдөлмөр эхлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ. Эцсийн дүнд хөдөлмөр эрхлэлт 6.4%, өрхийн орлого, хэрэглээ, хадгаламж тус бүр 4.1%-аар буурна. Улмаар бодит ДНБ 1.9%-аар буурна.

◀ Сөрөг хувилбар:

Экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ буурах тул төсвийн зарлагын бууралтын эдийн засагт үзүүлэх нөлөө нь суурь хувилбартай харьцуулахад илүү чанга тусна. Үйлдвэрлэл бараг бүх салбарт буурах ба засгийн газрын хэрэглээнээс хэт хамааралтай салбаруудад хамгийн их бууралт ажиглагдана. Эцсийн дүнд бодит ДНБ 7.9%-аар буурна.

◀ Эерэг хувилбар:


Экспортын бүтээгдэхүүний үнэ өсөлттэй байх үед төсвийн зарлагыг бууруулахад сөрөг нөлөө нь зөөлөн тусна. Үнийн өсөлтийн нөлөө төсвийн зарлагын бууралтын сөрөг нөлөөнөөс илүү байх тул бодит ДНБ 3.9%-аар өснө. Экспортын бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээлийн үнэ дахин 8%-аар өсөхөд, төсвийн зарлагаа танахгүйгээр төсвийн алдагдлыг зорилтот түвшинд хүргэх болом бүрдэхээр байна.

Шатахууны үнийн өсөлтийн эдийн засаг дахь нөлөө

Энэхүү судалгааг Эдийн засгийн бодлогын хамтын ажиллагааны байгууллага (PEP)-ын санхүүгийн болон арга зүйн дэмжлэгтэйгээр “Институтийг дэмжих төсөл” (ISP)-ийн хүрээнд гүйцэтгэв.

Монгол Улс дотоодын шатахууны эрэлтээ 100% импортоор хангадаг ба голчлон ОХУ-аас импортолдог. Иймээс дотоодын зах зээлийн шатахууны үнэ дэлхийн зах зээлийн үнээс шууд хамаардаг.

Зураг 4. Шатахууны үнийн өөрчлөлт, %



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар, Нийслэлийн статистикийн газар, Дэлхийн банк

Зураг 1-ээс шатахууны хил дээрх үнийн өөрчлөлт дэлхийн үнийн өөрчлөлтийг дагаж буйг харж болно. Харин дотоодын үнийн өөрчлөлт хил дээрх болон дэлхийн үнэтэй харьцуулахад тогтвортой байна. Энэ нь үнийн хэлбэлзлийн нөлөөг багасгах зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлсэн татварын бодлоготой холбоотой. Тодруулбал, хилийн үнэ өөрчлөгдөхөд Засгийн газар шатахууны онцгой албан татварыг эсрэг чиглэлд өөрчилж байсан билээ.

Засгийн газар ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсаны дагуу төсвийн алдагдлыг бууруулахын тулд 2017 оны долоо болон аравдугаар сард шатахууны онцгой албан татварын хувийг нэмэгдүүлсэн. Гэвч газрын тосны дэлхийн үнэ өссөнөөр төсвийн алдагдлыг бууруулахын зэрэгцээ дотоодын үнийг тогтвортой хадгалахад хүндрэлтэй болсон. Иймээс Засгийн газар төсвийн алдагдлыг бууруулах, эсвэл онцгой албан татварыг бууруулан дотоодын үнийг тогтвортой хадгалах гэсэн сонголттой тулгараад байна.

Судалгааны баг шатахууны импортын үнийн өсөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлахдаа Засгийн газрын бодлогын боломжит дараах 3 хувилбарыг харьцуулав.

1. Засгийн газар татварыг өөрчлөхгүй, дотоодын үнэ зах зээлийн зарчмаар өөрчлөгдөх – Засгийн газар төсвийн алдагдлаа бууруулах.
2. Засгийн газар онцгой албан татварыг өөрчлөх замаар дотоодын үнийг тогтвортой хадгалах.
3. Засгийн газрын хувьд төсвийн алдагдлыг бууруулахын тулд татвар нэмэх, эсвэл бараа үйлчилгээний зардлаа хасах аль аль нь хэцүү. Гэвч ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд гадаадаас хөрөнгө татахыг зөвшөөрч байгаа. Иймээс өөр нэг хувилбар - Засгийн газар татвараа бууруулах ба үүнээс үүдсэн бүх зардлыг гадаадын зээлээр санхүүжүүлэх.

Импортын шатахууны үнийн өсөлтийн нөлөөг үнэлэхийн тулд судалгааны баг РЕР стандартын ерөнхий тэнцвэрийн загварын статик хувилбарыг боловсруулсан. Мөн 2014 оны Нийгмийн тооцооллын хүснэгтийг шинжилгээний гол тоон өгөгдөл болгон ашигласан.

Судалгааны гол үр дүн:

- ◀ Бодлогын эхний хувилбарын үед үйлдвэрлэлийн зардал өссөнөөр дотоодын үйлдвэрлэл буурч, улмаар ажилгүйдлийн түвшин өснө. Мөн үнийн ерөнхий түвшний өсөлт болон өрхийн орлогын бууралт хэрэглэгчдийн бодит худалдан авах чадварыг бууруулна. Дотоодын эрэлт, нийлүүлэлт хумигдаж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө.
- ◀ Хэрвээ Засгийн газар онцгой албан татварыг бууруулбал, 164 тэрбум төгрөгийн татаас шаардлагатай ба үүнийг хөрөнгө оруулалт татах замаар санхүүжүүлнэ. Засгийн газрын хөрөнгө оруулалт буурснаар нийт хөрөнгө оруулалт, цаашлаад нийт эрэлтийг хумина. Энэ нь үйлдвэрлэлийн түвшнийг бууруулснаар ажилгүйдлийг нэмэгдүүлнэ. Эцсийн дүнд хэрэглэгч, үйлдвэрлэгчийн сайн сайхан байдал буурч байгаа ч, сөрөг нөлөө нь эхний хувилбартай харьцуулахад бага байна.
- ◀ Татаасны зардлыг гадаадын зээлээр санхүүжүүлэх нь дотоодын зах зээлд ямар нэгэн нөлөө байхгүй боловч засгийн газрын өр ихээхэн нэмэгдэнэ. Энэ нь урт хугацаандаа эдийн засагт сөрөг нөлөөтэй юм.

Нэмэлт шинжилгээ: Ядууралд үзүүлэх нөлөөлөл

Нэмэлт шинжилгээний гол зорилго нь шатахууны үнийн өсөлтийн өрхийн түвшинд, ялангуяа ядууралд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд оршино. Судалгааны баг Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг (ӨНЭЗС-2014) ашиглан дээрх макро үр дүнг нарийвчилж микро үр дүн гаргах аргачлалыг (top-down) хэрэглэсэн.

Шинжилгээний гол үр дүн:

- ◀ Шатахууны үнэ өсөх үед Засгийн газар ямар нэгэн интервенц хийхгүй байвал ядуурлын хамралтын хүрээ тэлэх ба орон нутгийн өрхүүдийн хувьд ядуурал илүү гүнзгий болно.
- ◀ Засгийн газар татаас өгөх замаар шатахууны үнийг барьснаар ядуурал нэмэгдэх ч сөрөг нөлөөлөл нь эхний хувилбараас харьцангуй бага байна.
- ◀ Хэрэв Засгийн газар татааснаас үүдсэн алдагдлаа гадаадын зээлээр санхүүжүүлбэл богино хугацаанд ядууралд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
- ◀ Өрхийн тэргүүн нь боловсрол багатай өрхүүд, эсвэл орон нутгийн өрхүүд ядууралд илүү өртөх хандлагатай байдаг учраас эдгээр өрх шатахууны үнийн өсөлтийн сөрөг нөлөөнд илүү өртөмтгий байна.

Тус судалгааны дэлгэрэнгүй тайланг ЭЗСЭШХ-ийн цахим хуудас (www.eri.mn)-аас унших боломжтой.

Байгалийн баялагтай эдийн засаг дахь мөнгөний болон макро зохистой харьцааны бодлогын нөлөө: **Монголын жишээ**

Дэлхий дахиныг хамарсан 2008-2009 оны санхүү, эдийн засгийн хямралаас хойш санхүүгийн тогтвортой байдал макро эдийн засгийн тогтворжилтод чухал үүрэгтэйг онцлох болжээ. Ялангуяа санхүүгийн үр ашигтай, тогтвортой байдалд макро зохистой харьцааны бодлогын арга хэрэгслүүдийн ач холбогдол илүү нэмэгджээ.

Макро зохистой харьцааны бодлого нь системийн эрсдэл, санхүүгийн тогтвортой бус байдлыг үүсгэх сөрөг нөлөөнүүдийг арилгахад чиглэсэн бодлогын арга хэрэгслүүдийн цогц юм. Дэлхий даяар макро зохистой харьцааны бодлогыг түгээмэл хэрэглэх болсон бөгөөд үүнд олон төрлийн бодлогын арга хэрэгслийг ашиглаж байна. Эдгээр арга хэрэгслийг ерөнхийд нь дараах 5 бүлэгт ангилж авч үздэг. Үүнд:

- ◀ *Өөрийн хөрөнгийн арга хэрэгслүүд*
- ◀ *Банкны бэлэн нөөцийг зохицуулах арга хэрэгслүүд*
- ◀ *Зээлийг зохицуулах арга хэрэгслүүд*
- ◀ *Татварын арга хэрэгслүүд*
- ◀ *Захиргааны арга хэрэгслүүд.*

Түүнчлэн, эдгээр арга хэрэгслийг дараах үндсэн 3 төрлийн сөрөг нөлөөг багасгахад хэрэглэх боломжтой. Үүнд:

- ◀ Стратегийн уялдаа: Санхүүгийн зуучлалын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаанаас үүсэх эрсдэлүүд.
- ◀ Мөнгөн үнэлгээний дам нөлөө: Аливаа санхүүгийн байгууллага активаа хямдруулан зарж эхлэхэд өөр санхүүгийн байгууллагын тэнцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэл.
- ◀ Харилцан хамааралт байдлын дам нөлөө: Санхүүгийн байгууллагуудын хоорондоо холбоотой үйл ажиллагаанаас үүдэлтэй системийн шинжтэй, нийт салбарыг хамарсан эрсдэл.

Санхүүгийн салбарт гарсан хүндрэл дээрх дам нөлөөгөөр дамжин системийг хамрах үед зохистой макро зохистой харьцааны арга хэрэгслүүдийг сонгон ашиглах нь үр дүнтэй.

Манай орны хувьд макро зохистой харьцааны бодлого илүү тогтонги, санхүүгийн салбарын болон эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдан тэр бүр өөрчлөгддөггүй. Хэдий тийм ч цаашид эдгээр бодлогын арга хэрэгслийг банк, санхүүгийн салбар болон макро эдийн засгийг тогтворжуулахад ашиглах шаардлагатай.

Судалгааны баг хөдөлмөрийн зах зээл, зээлийн зах зээл, мөнгөний бодлого (гадаад валютын зах зээл дээр интервенцийг оруулаагүй), макро зохистой бодлогын зарим арга хэрэгсэл (заавал байлгах нөөцийн норм, өөрийн хөрөнгийн шаардлага гэх мэт) болон эрдэс бүтээгдэхүүний үнийн шок зэргийг багтаасан жижиг, бүтцийн нээлттэй эдийн засгийг загварчилсан. Тус загварт 2005-2016 онд Монголын улирлын тоон мэдээллийг ашиглан Бейсийн техникээр дээр дурдсан хоёр арга хэрэгслийн нөлөөг тооцоолсон. Судалгааны гол үр дүнг тоймловол:

- ◀ Эдийн засгийн мөчлөгт гадаад болон засгийн газрын зардлын шокуудын нөлөө хүчтэй, харин мөнгөний болон макро зохистой бодлогын нөлөө сул байна.
- ◀ Зээлийн өсөлтийг хязгаарлах (эсвэл зээлийн хүүг өөрчлөхөд)-д заавал байлгах нөөц, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь бодлогын хүүтэй харьцуулахад илүү нөлөөтэй байна.
- ◀ Мөнгөний бодлого нь валютын ханш, инфляцын хэлбэлзлийг бууруулахад макро зохистой бодлоготой харьцуулахад илүү үр дүнтэй байна.

Иймд мөнгөний болон макро зохистой бодлогыг хослуулан ашиглавал эдийн засгийн болон санхүүгийн санхүүгийн мөчлөгийн сөрөг нөлөөг бууруулахад тусална.


Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл зэрэг бодлого боловсруулагч байгууллагуудын үүрэг, оролцоо макро зохистой харьцааны бодлогыг авч хэрэгжүүлэхэд маш чухал. Мөн бодлогын хэрэгжилтийн үе шат бүрд оролцож буй хэрэгжүүлэгч болон бодлого боловсруулагч байгууллагуудын үүрэг маш тодорхой, үйл ажиллагааны хоорондын нягт уялдааг хангах нь нэн чухал юм. Үр ашигтай хууль, эрх зүйн орчин бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нэгэн гол хүчин зүйл гэдгийг анхаарах хэрэгтэй.

Бэлчээрийн доройтол ба малын хөлийн татвар

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хэмжээнд таван хошуу малын тоо хурдацтай өссөнөөр, бэлчээрийн даац хэтэрч, бэлчээрийн доройтол нэмэгдсээр байна. Гэхдээ манай улсад энэ төрлийн судалгаа ховор байгаа юм. Бэлчээрийн даацыг экологи болон эдийн засгийн бэлчээрийн даац хэмээн хоёр ангилдаг бөгөөд олон улсад хийгдсэн судалгаануудад бэлчээрийн эдийн засгийн даац экологийн даацаас өндөр байдаг учраас татвар, квот гэх мэт арга хэрэгслээр бэлчээрийн эдийн засгийн даацыг экологийн даацтай тэнцүү болгож, бэлчээрийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай гэж үздэг. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын бэлчээрийн экологи болон эдийн засгийн даацыг тооцож, малын хөлийн татварын хэмжээг тодорхойлоход оршино.

Урт хугацааны нормчилсон ялгаатай биомассын индекс (NDVI)-ийг ашиглан бэлчээр ашиглалтын индексийг тооцож, нийт 330 сумын бэлчээрийн доройтол хэр байгааг үнэлэв. Доорх зургаас бэлчээрийн даац 1-3 (шар), 3-5 (бүдэг улаан) болон 5-аас (улаан) олон дахин хэтэрсэн сумдыг харж болно.

Зураг 5. Монгол Улсын бэлчээр ашиглалтын индекс



Эх үүсвэр: Судлаачийн тооцоо

Энэхүү судалгаанд бэлчээрийн даац 500% хэтэрсэн 71 сумыг сонгон авч, тэдгээрийн бэлчээрийн экологи болон эдийн засгийн даацыг тооцож, үүнийг ашиглан эдийн засгийн бэлчээрийн даацыг экологийн даацтай тэнцүү болгох малын хөлийн татварын хэмжээг тодорхойлсон. Бэлчээрийн эдийн засгийн даац малчин өрхийн орлого, зарлагаар тодорхойлогдох ба энд 2016 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-г ашиглалаа. Малчин өрхийн орлого, зарлагыг хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор хуваасан тэнцүү 10 бүлгээр тооцлоо. Ингэхдээ Энх-Амгалан (2013) судалгаанд дурдсан малын идэлтийн коэффициентийг ашиглан хонин толгойд шилжүүлээ (ямаа-2 хонь, адуу-8 хонь, тэмээ-3 хонь, үхэр-4 хонь).

Судалгаанаас гарсан зарим үр дүнг доор танилцууллаа. Үүнд:

- ◀ Малчин өрхийн мал нядалснаас олох орлого нь малаас олох нийт орлогын 80-95%-ийг эзэлдэг бөгөөд малын тоо цөөн байх тусам энэ орлогын малаас олох нийт орлогод эзлэх хувь их байдаг.
- ◀ Малын тоогоор хамгийн бага 4 бүлгийн малчин өрхөд мал тэжээх нь илүү зардалтай, нядлах нь илүү ашигтай байгаа бол 5 ба түүнээс дээших бүлгийн малчдад малаа тэжээж, ашиг шим хүртэх нь эдийн засгийн хувьд илүү ашигтай байна. Өөрөөр хэлбэл, малын тоо ихсэх тусам малын амьдын орлого (ноос, ноолуур, сүү г.м) нь амьжиргааны зардлаа нөхөхөд хангалттай байдаг тул малчдын малаа нядлах сонирхол буурч, олон малтай малчид малаа улам өсгөх шийдвэр гаргаж байна. Иймээс малын хөлийн татвар ноогдуулж, малаа тэжээж өсгөх үеийн зардлыг нь нэмэх замаар бэлчээрийн эдийн засгийн даацыг экологийн даацад ойртуулах арга үр дүнтэй байж болох юм.
- ◀ Нэг малд ноогдуулах дундаж татварын хэмжээ 200 төгрөг байхад бэлчээрийн доройтол 500% хэтэрсэн сумууд 2038 онд бэлчээрийн ашиглалтын хэвийн түвшинд хүрнэ. Харин татварыг 500 төгрөг болгоход хэвийн түвшинд хүрэх он 2032 болж наашилна. Хэрвээ татварын хэмжээг 1000 төгрөгөөр тогтоовол 2022 он гэхэд бэлчээрийн ашиглалт хэвийн хэмжээнд хүрэх тооцоо гарч байна.
- ◀ Энэ судалгаанд малын тоогоор ялгаатай 10 бүлгийн өрхүүдэд тогтмол татвар ноогдуулах тохиолдлыг авч үзсэн. Гэхдээ манай улсад тогтмол татвараас илүүтэйгээр малын тооноос хамаарсан өсөн нэмэгдэх татвар тохиромжтой байж болох юм.


Уул уурхайн салбарын орон нутгийн өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөө: Монголын жишээ

2010-2016 онд Монголын эдийн засгийн өсөлт уул уурхайн салбараас хамааран хүчтэй савласан билээ. Энэ хугацаанд хөдөө орон нутгийн иргэдийн ядуурлын түвшин нийслэлийн иргэдийнхээс илүү хурдтай буурчээ. Орон нутгийн иргэдийн амьжиргаанд гарсан энэ өөрчлөлт уул уурхайн салбарын орон нутаг дахь үйл ажиллагаатай хэр холбоотой вэ?

Уул уурхайн салбарын орон нутгийн түвшинд үзүүлэх нөлөөг судалсан олон улсын зарим судалгаанд, орон нутагт уурхай нээгдсэнээр эдийн засгийн бусад салбар шахагдаж “Голланд өвчин” тохиолддог (Aragon, Chuhano-Pole, & Land, 2014; James & Aadland, 2011; Papyrakis & Gerlagh, 2007), эсвэл уул уурхайн татвараар санхүүжсэн орон нутгийн төрийн хөрөнгө оруулалт бусад салбараа шахан гаргаж “Перу өвчин” тохиолддог (Cust & Vaile, 2016)-ийг тогтоосон байдаг. Мөн уул уурхайн хөгжил орон нутаг дахь ядуурлыг бууруулдаг (Gamu, Billon, & Spiegel, 2015) боловч орон нутаг хоорондын тэгш бус байдлыг гүнзгийрүүлдэг, орон нутгийн засаглалыг сулруулж авлигыг гааруулах тохиолдол гардаг ажээ (Loyaza, Mier y Teran, & Rigolini, 2003; Aragon & Rud, 2013)

Энэ судалгаанд гурван төрлийн тоон мэдээллийг нэгтгэж ашигласан. Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга байгууллагын цахим мэдээллийн сан дахь 2009-2015 оны уул уурхайн компаниудын төлсөн татвар ба хүчинтэй лицензийн мэдээллийг сумын түвшинд авч ашигласан. Үндэсний статистикийн хорооны Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2010-2016 оны анхдагч тоон мэдээллээс өрхийн үндсэн мэдээллийг, мөн тус хорооны мэдээллийн сангаас сумдын 2010-2016 оны эдийн засаг, нийгмийн үндсэн мэдээллийг тус тус авч нэгтгэсэн.

Зураг 6. Өрхийн нэг хүнд ногдох сарын нэрлэсэн орлого, мян.төг



Зураг 1-д харуулснаар, уул уурхайтай сумдад өрхийн орлого бусад өрхийн орлогоос мэдэгдэхүйц өндөр байна. Гэхдээ энэ ялгааг тухайн сумдын болон өрхийн эдийн засаг, нийгмийн шинж онцлогуудаас ялгаж тооцохын тулд 42 мянган өрхийн мэдээллийг давтагдах хөндлөн өгөгдлийн (pooled cross-sectional) регрессийн шинжилгээний аргаар үнэлсэн. Нарийвчилсан үнэлгээний үр дүнд, уул уурхайтай сумдад өрхийн нэрлэсэн ба бодит орлого аль аль нь уул уурхайгүй сумынхаас 7% илүү байна. Нийт орлогыг дагаад өрхийн хэрэглээ уул уурхайтай сумдад 11% илүү, өрхийн ядуу байх магадлал 7,5% доогуур байна. Өрхийн орлогод гарсан эерэг нөлөө голчлон өрхийн цалингийн орлогоор дамжиж байна. Тухайлбал, уул уурхайтай сумдын өрхийн цалингийн орлого бусад сумын өрхөөс 7% илүү байна. Харин өрхүүдийн тэтгэвэр, МАА-н орлого, өрхийн өөрийн үйлдвэрлэл, бизнесийн орлого уул уурхайтай сумдад төдийлөн ялгаатай биш байна.

Уул уурхайн үйл ажиллагаа орон нутгийн эдийн засаг дахь нийт эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байдаг боловч манай улсын хувьд энэ нөлөө сул байна. Тухайлбал, уул уурхайтай сумдад өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, байр сууцны түрээс бусад сумаас бараг ялгаагүй байна. Харин өрхийн гишүүдийн ажил эрхлэлт, эрүүл мэндтэй холбоотой зарим үзүүлэлт уул уурхайтай сумдад бага зэрэг доогуур үнэлэгдсэн.

Уул уурхайн салбарын дээрх нөлөөг дараах шалтгаануудтай холбон тайлбарлаж болох юм. Үүнд:

- ◀ Уул уурхайн салбар сумын түвшинд гэхээсээ улсын түвшинд хувь нэмэр ихтэй, улсын төсвөөр дамжин бүх өрхийн амьжиргаанд жигд нөлөө үзүүлдэг тул уул уурхайн ба уул уурхайн бус сумын өрхүүдийн амьжиргааны түвшин төдийлөн ялгаа багатай.
- ◀ Хөдөө орон нутагт нөөц ашиглалт сул байдаг учраас уул уурхайн үйл ажиллагаа идэвхэжсэнээр уул уурхайн бус салбарт дарамт учраагүй
- ◀ Уул уурхай ажиллах хүчин бага шингээдэг тул сумдад албан уурхайд ажил эрхлэлт бага
- ◀ Уул уурхайн компаниуд орон нутгаас худалдан авалт багатай
- ◀ Байгаль орчны бохирдол, бэлчээрийн хязгаарлалтаар дамжин өрхийн амьжиргаанд сөрөг нөлөөлөх магадлалтай
- ◀ Орон нутгийн захиргааны чадавх, институцийн сул хөгжил нь уул уурхайн салбарын үр шимийг орон нутгийн иргэдэд хүргэх үр ашгийг бууруулж байж болох юм

Иймээс уул уурхайн салбарын орон нутгийн өрхийн амьжиргаанд үзүүлэх эерэг нөлөөг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай:

- ✓ Хүртээмжтэй өсөлтөд чиглэх. Үүний тулд, олборлох салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн институц, төрийн албаны чадавхыг

бэхжүүлэх, авлигатай тэмцэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчин ба нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах

- ✓ Орон нутаг хоорондын хөгжлийн ялгааг багасгах. Үүний тулд, эрдэс баялгийн орлогын менежментийг оновчтой шийдэх, сумдын орон нутгийн хөгжлийн сан, төсвийн дэмжлэгийг үргэлжлүүлэх, гэхдээ “Перу өвчин”-өөс сэргийлэх
- ✓ Уул уурхайн бус салбар шахагдахаас сэргийлэх. Үүний тулд, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлж, ажиллах хүч, нөөцийг орон нутаг хооронд чөлөөтэй шилжих нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Нийт эдийн засаг дахь эерэг нөлөөг орон нутгийн явцуу эрх ашгаас дээгүүр тавих. Уул уурхайн компаниудыг орон нутгаас ажиллах хүч авах, худалдан авалт хийх, хандив тусламж үзүүлэхийг шаардах нь салбарын үр ашиг ба нийт татварын орлогыг бууруулах нөлөөтэй байж болохыг анхаарах хэрэгтэй.

Ипотекийн зээлийн бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө

Уг судалгааны ажлаар манай улсын өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн орон сууцны зээлийн хөтөлбөрийн эдийн засагт үзүүлэх шууд, шууд бус, өдөөгдсөн нөлөөг харьцуулан судлах аргазүй болон том хэмжээний бейсийн вектор авторегрессив загвар ашиглан тоон утгаар хэмжихийг зорилоо.

Орон сууцны зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөөг ерөнхийд нь эдийн засгийн өсөлт ба ажил эрхлэлт гэсэн хоёр сувагт хуваан авч үзэж болно. Эдгээр сувгийг цааш нь нарийвчилж, дэд механизмуудад задалж, дэлгэрэнгүй тайлбарлах боломжтой. Тодруулбал, орон сууцны зээл эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж, улмаар үүний үр дүнд орон сууцны зах зээлийн хөгжил, капиталын зардал, хадгаламж, татварын орлого, орон сууцны фондод нөлөөлнө.

Манай улсын хувьд 2013 оноос өмнө арилжааны банкнууд өөрийн эх үүсвэр болон зарим олон улсын байгууллагын хөнгөлөлттэй нөхцөл бүхий эх үүсвэрээр орон сууцны зээл санхүүжүүлж байжээ. Харин 2013 оны III улирлаас “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТТБХ)-ийн хүрээнд 8 хувийн зээлийг олгож эхэлснээр орон сууцны эрэлт огцом нэмэгдсэнийг статистик тодорхой харуулж байна. Тухайлбал, 2013 онд орон сууцны зээлийн үлдэгдэл хамгийн өндөр буюу 129,4 хувиар өсжээ. Харин 2017 оны III улирлын байдлаар орон сууцны зээлийн өрийн үлдэгдэл 4,2 их наяд төгрөг болж, нийт зээлдэгчийн тоо 92 616 хүрчээ. Орон сууцны зээлийн өрийн үлдэгдлийн өсөлт улам бүр буурсаар байгаа нь орон сууцны зах зээл хумигдсаар байгааг харуулж байна. Цаашилбал, орон сууцны үнэ ОСИСТТБХ-ийн нөлөөгөөр 2014 оны II улирал хүртэл огцом өсөж, тасралтгүй буурсаар 2017 оны III улирлын байдлаар 2013 оны I улирлын түвшиндээ хүрээд байгааг орон сууцны үнийн хедоник индексийн өөрчлөлтөөс тодорхой харж болно. Өрхийн өр ба орлогын харьцаа 2013 оны I улиралд 39 хувь байсан бол 2017 оны III улирлын байдлаар 83 хувь болж өссөний шалтгааныг нэг талаас орон сууцны зээлийн хөтөлбөртэй холбон тайлбарлах нь зүйн хэрэг юм. Мөн эндээс “Өнгөрсөн хугацаанд ямар орлоготой хүмүүс орон сууцны зээл авсан бэ?”, “Одоо хэн орон сууцны зээл авах боломжтой вэ?” гэсэн сонирхолтой асуултууд урган гарч байгааг анхаарвал зохилтой.

Судалгаанд ашигласан аргазүй болох том хэмжээний бейсийн авторегрессив загварын давуу тал бол энгийн вектор авторегрессив загвартай харьцуулахад эндоген хувьсагчдын тоог хязгаарлах шаардлагагүй, орхигдсон хувьсагчийн гажуудлаас зайлсхийх боломжтой, цэгэн таамаглалын алдааны вариацийг бууруулах боломжийг олгодог зэрэг юм. Тодруулбал, Бэанбура, бусад судлаач нарын 2010 оны ажилдаа авч үзсэн бейсийн агшаалттай вектор авторегрессив загварын ерөнхий аргазүйг энэ судалгаанд шууд ашиглана. Уг аргазүйг манай улсын практик анх Ган-Очир, Даваажаргал нар монголын эдийн засагт нөлөөлж буй гадаад шокын нөлөөг үнэлэх зорилгоор 16 болон

24 хувьсагчтай том хэмжээний бейсийн авторегрессив загвар байгуулж, үнэлэхдээ ашигласан байдаг. (Ган-Очир & Даваажаргал, 2017)

Өгөгдлийн хувьд 2008 оны I улирлаас 2017 оны IV улирлын хоорондох тухайн улиралд олгосон орон сууцны зээл, барилгын салбарын бодит ДНБ, барилгын салбарын ажил эрхлэлт, барилгын салбарын тухайн улиралд авсан зээл, барилгын салбарын цалин, барилгын материалын импорт, өрхийн сарын дундаж зарлага, орон сууцны үйлдвэрлэл, банкнуудын өөрийн хөрөнгө ба нийт активын харьцаа, зэсийн үнэ, нүүрсний үнэ гэсэн хувьсагчдыг сонголоо. Бэанбура, бусад судлаач нарын аргазүйд үндэслэн Вишард праиор тархалтын гипер параметрууд болох $\lambda=0,3125, \tau=3,125$ байхаар сонгож, бейсийн үнэлгээг хийв. Орон сууцны зээлийн зээлийн шокд гадаад секторын хувьсагчдаас бусад хувьсагчийн үзүүлэх хариу үйлдлийг шинжлэх замаар вариаци задаргаа хийж, дүгнэлт хийсэн. Вариаци задаргааг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Орон сууцны зээлийн нөлөө

Д/Д	Хувьсагчийн нэр	Орон сууцны зээлийн шок
1	Барилгын салбарын БДНБ	5,3 хувь
2	Барилгын салбарын ажил эрхлэлт	2,0 хувь
3	Барилгын салбарын тухайн улиралд авсан зээл	3,9 хувь
4	Барилгын салбарын цалин	12,3 хувь
5	Барилгын материалын импорт	8,0 хувь
6	Өрхийн сарын дундаж зарлага	3,8 хувь
7	Орон сууцны үйлдвэрлэл	9,7 хувь

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Вариаци задаргаанаас харахад барилгын салбарын бодит ДНБ-ий хэлбэлзлийн 5,3 хувийг, барилгын салбарын ажил эрхлэлтийн хэлбэлзлийн 2,0 хувийг, барилгын салбарын цалингийн хэлбэлзлийн 12,3 хувийг орон сууцны зээлийн шок тус тус тайлбарлаж байна. Бейсийн авторегрессив загварын тогтворжилтын шинжилгээг хугацааны хоцрогдлыг ялгаатай сонгох, хувьсагчдын тоог нэмэх замаар хийж үзэхэд дээрх үр дүн харьцангуй тогтвортой байсан болно.

Эцэст нь дүгнэвэл 2013 оны II хагасаас олгож эхэлсэн ОСИСТТБХ манай эдийн засагт өнгөрсөн хугацаанд барилгын салбар, цаашилбал, уг салбартай холбоотой дэд салбаруудад эергээр нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна. Үүнийг орон сууцны зээлийн барилгын салбарын бодит ДНБ, орон сууцны үйлдвэрлэл, боловсруулах салбарын зарим нэрийн бүтэгдэхүүний үйлдвэрлэлд үзүүлсэн нөлөөнөөс харж болно. Том хэмжээний бейсийн авторегрессив загварын орон сууцны зээлийн шокны вариаци задаргааны үр дүн дээрх дүгнэлтийг баталж байна. Харьцуулсан шинжилгээнээс харахад ОСИСТТБХ 2013 оны II хагасаас орон сууцны үнэ огцом өсөхөд нөлөөлсөн бөгөөд 2014 оны II улирлаас тасралтгүй буурсан орон сууцны үнэ 2017 оны III улирлын байдлаар 2013 оны I улирлын түвшиндээ очжээ. Цаашид ОСИСТТБХ-ийг үргэлжлүүлэхийн тулд "Одоо хэн орон сууцны зээл авах боломжтой вэ?" гэдгийг зайлшгүй судлах шаардлагатайг өрхийн өр ба орлогын харьцаа 2017 оны III улирлын байдлаар 83 хувьд хүрсэн үр дүн ойлгомжтой харуулж байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, 2017 он

Тус хүрээлэн “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд сумын орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 2017 оны гуравдугаар улиралд гүйцэтгэсэн. Үнэлгээнд Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Төв, Өвөрхангай зэрэг 6 аймгийн 119 сумыг хамруулсан.

Сайн засаглалын үр дүнд суурилсан урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Монгол Улсын бүх сумын засаглалын түвшнийг жилийн гүйцэтгэлээр үнэлэх бөгөөд энэ үнэлгээнд үндэслэн болзол хангасан сумд тодорхой хэмжээний төсвийн урамшуулал авах юм. Сумдын засаглалын түвшнийг үнэлэхдээ тусгайлан боловсруулсан үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх аргачлалд тулгуурласан. Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь ОНХС-гийн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм журмын хүрээнд сумдын засаглалыг дараах 6 түвшинд тодорхойлохоор авч үзсэн. Үүнд:

1. 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэхэд иргэдийн оролцоог хангаж буй байдал
2. 2017 оны төсвийн төлөвлөлт, бэлтгэлийг хангасан байдал
3. 2016, 2017 оны төсвийн талаар олон нийтэд ил тод мэдээлж буй байдал
4. 2016 оны төсвийн гүйцэтгэл
5. 2016 оны төсвийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, хяналт шалгалт хийсэн байдал
6. 2016 оны төсвийн гүйцэтгэлээр бий болсон сумын хөрөнгийн өмчлөл, ашиглалтын байдал.

Энэхүү үнэлгээнд 2015-2017 онд ОНХС-д улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хууль журмын дагуу хэрхэн зарцуулсан талаар сумдын гүйцэтгэсэн ажлын тайлан, төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой баримт бичгийг үндэслэн тусгай аргачлалаар үнэлгээг гүйцэтгэсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн ажилд дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашигласан. Үүнд:

- ◀ Төрийн хяналт шалгалтын стандарт,
- ◀ Төрийн аудитын тухай хууль,
- ◀ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ◀ Төсвийн тухай хууль
- ◀ Нэгдсэн төсвийн тухай хууль,
- ◀ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- ◀ Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль
- ◀ Сангийн сайдын 2012 оны 244, 290, 264 дүгээр тушаал
- ◀ Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал
- ◀ Бусад холбогдох эрх зүйн актууд